



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/НЗЗ

Чингис хот

2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг  
зохион байгуулж явуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Засгийн газрын 2019 оны мн/250 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалт, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны н/165 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ.

1. 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 05-наас 10 дугаар сарын 25-ны хооронд явуулсугай.

2. 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын товчоог дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                       |              |                                                        |
|-----------------------|--------------|--------------------------------------------------------|
| Товчооны дарга:       | Ж.Ганбаатар  | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга              |
| Орлогч дарга:         | Н.Хүрэлээ    | -Цэргийн штабын дарга, хурандаа                        |
| Гишүүд:               | Ж.Эрдэнэбат  | -Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа             |
|                       | Б.Батсайхан  | -Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа          |
|                       | Н.Алтангэрэл | -Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа                |
|                       | Д.Баасандорж | -Эрүүл мэндийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч          |
|                       | Д.Оюунгэрэл  | -Нэгдсэн эмнэлгийн дарга                               |
|                       | Ц.Баярмаа    | -Нийгмийн даатгалын хэлтсийн дарга                     |
|                       | Г.Дашдаваа   | -Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төвийн захирал   |
| Нарийн бичгийн дарга: | Б.Энх-Эрдэнэ | -Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч |
|                       | Л.Цэнддорж   | Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, хошууч           |

3. Цэрэг татлагын хуваарийг 1 дүгээр, зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагаар Зэвсэгт хүчний Жанжин штабаас тогтоосон хяналтын тоог баримтлан хуульд заасан шаардлага хангасан залуучуудыг хугацаат цэргийн

201910565

албанд татаж, 10 дугаар сарын 20-нд багтаан алба хаах цэргийн ангиудад хүлээлгэн өгч, дүнг 10 дугаар сарын 25-нд танилцуулахыг Цэрэг татлагын товчоо/Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

5. Цэрэг татлагын эмч нарын үзлэгийг "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын дагуу шинжилгээ, оношлогоог үндэслэн чанартай зохион байгуулахыг Нэгдсэн эмнэлэг /Д.Оюунгэрэл/-т, цэргийн албанд татагдагчдын эрүүл мэндийн байдлын талаар судалгаа хийх, эмчлэгдэн эдгэрэх боломжтой залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар /Д.Баасандорж/-т, цэргийн албанд татагдагчдын боловсролын түвшинг харгалзан үзэх, бичиг үсэг үл мэдэгч, бага боловсролтой иргэдийг албан бус сургалтанд хамруулан боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Насан туршийн боловсролын "Гэгээрэл" төв /Г.Дашдаваа/-д, цэргийн албанд татагдагчдын гэмт хэрэг зөрчилд холбогдсж байсан эсэхийг хянах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-т, цэрэг татлагын байрны дотоод дэг журам сахиулах, цэрэг татлагын товчооны ажилд дэмжлэг үзүүлэхийг Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-т, цэргийн албанд татагдагчдын болон тэдний ар гэрийн талаар нарийвчлан судлахыг Тагнуулын хэлтэс /дэд хурандаа Н.Алтангэрэл/-т, цэргийн албанд татагдагчдыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамруулж, бичиг баримтад тэмдэглэл хийхийг Нийгмийн даатгалын хэлтэс /Ц.Баярмаа/-т тус тус үүрэг болгосугай.

6. Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтанд орсон цэргийн албанд татагдагч бүрт хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгах, тэдний бичиг баримтыг бүрдүүлэх, сумын эрүүл мэндийн төвд цусны бүлэг тогтоох, хэвлийн чанд авиан оношлогоо, шээсний шинжилгээг урьдчилан хийсэн байх, Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангах, Цэргийн албанд татагдагсaдыг үдэж мордуулах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авах, тэднийг ажлын байранд зуучлах ажлыг сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бие бүрэлдэхүүнийг үүрэг даалгавараар хангаж, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, цэргийн албанд татагдагсaдыг аймгийн цэрэг татлагын байранд ирүүлэх, цэргийн албанаас халагдагсaдыг бичиг баримттай нь хүлээн авч, цэргийн тоо бүртгэлд тусган, сумдын ЗДТГ-ын дарга нарт хүлээлгэн өгч, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулахыг Цэргийн штаб /хурандаа Н.Хүрэлээ/-т даалгасугай.

8. Цэрэг татлагын үед болон тээвэрлэлтийн явцад Цэрэг татлагын товчооны гишүүд, эмч нар болон цэргийн албанд татагдагчдыг Дэлхий нийтийг хамарсан цар тахал /Covid-19/-аас урьдчилан сэргийлэх, нэг удаагийн амны хаалт, ариутгалын бодисоор хангахыг сумын Засаг дарга нар болон Цэрэг татлагын товчоо /Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

8. 2020 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага зохион байгуулахад шаардагдах **6.711.950** /Зургаан сая, долоон зуун арван нэгэн мянга есөн зуун тавин/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Цэрэг татлагын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны 09  
дүгээр сарын 23 өдрийн 1/132 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

2020 ОНЫ 2 ДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

| №   | Сум, багийн<br>нэр | Үзлэгээр<br>орох хүний<br>тоо | Хяналтын<br>тоо | Цэрэг татлагад<br>орох газар | Үзлэгт бэлэн байх |       |
|-----|--------------------|-------------------------------|-----------------|------------------------------|-------------------|-------|
|     |                    |                               |                 |                              | Сар өдөр          | Цаг   |
| 1.  | Баянхутаг          | 133                           | 16              | Баянхутаг                    | X/05              | 09.00 |
| 2.  | Галшар             | 138                           | 17              | Галшар                       | X/05              | 16.00 |
| 3.  | Бор-Өндөр          | 424                           | 51              | Бор-Өндөр                    | X/06              | 10.00 |
| 4.  | Дархан             | 100                           | 12              | Дархан                       | X/08              | 09.00 |
| 5.  | Баянмөнх           | 61                            | 7               | Баянмөнх                     | X/08              | 15.00 |
| 6.  | Дэлгэрхаан         | 96                            | 11              | Дэлгэрхаан                   | X/09              | 09.00 |
| 7.  | ХБУлаан            | 19                            | 2               |                              |                   |       |
| 8.  | Цэнхэрмандал       | 72                            | 8               | Цэнхэрмандал                 | X/09              | 15.00 |
| 9.  | Жаргалтхаан        | 87                            | 10              | Жаргалтхаан                  | X/10              | 09.00 |
| 10. | Мөрөн              | 113                           | 14              | Мөрөн                        | X/10              | 15.00 |
| 11. | Хэрлэн             | 264                           | 31              | Хэрлэн                       | X/13              | 09.00 |
| 12. | Өлзийт             | 2                             | 1               | Хэрлэн                       | X/16              | 09.00 |
| 13. | Өмнөдэлгэр         | 6                             | 2               |                              |                   |       |
| 14. | Гурванбаян         | 2                             | 1               |                              |                   |       |
| 15. | Батширээт          | 3                             | 1               |                              |                   |       |
| 16. | Биндэр             | 5                             | 2               |                              |                   |       |
| 17. | Баян-Адрага        | 2                             | 1               |                              |                   |       |
| 18. | Дадал              | 2                             | 1               |                              |                   | 15.00 |
| 19. | Норовлин           | 4                             | 2               |                              |                   |       |
| 20. | Баян-Овоо          | 3                             | 1               |                              |                   |       |
| 21. | Батноров           | 3                             | 1               |                              |                   |       |
| 22. | Бэрх               | 4                             | 2               |                              |                   |       |
|     | Нийт дүн           | 1543                          | 194             |                              |                   |       |



Аймгийн Засаг даргын 2020 оны  
09 дугаар сарын 23 өдрийн АМБЗ  
захирамжийн нэгдүгээр хавсралт

2020 ОНЫ 1 ДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

| № | Зардлын төрөл                 | Төсөвлөсөн | Хянасан | Тайлбар |
|---|-------------------------------|------------|---------|---------|
| 1 | Хоолны зардал                 | 1.800.000  |         |         |
| 2 | Томилолт, урамшуулалын зардал | 2.532.000  |         |         |
| 3 | Бичиг хэргийн зардал          | 163.000    |         |         |
| 4 | Шатахууны зардал              | 2.216.950  |         |         |
|   | Нийт                          | 6.711.950  |         |         |

Нэг. Хоолны зардал

| № | Сар өдөр | Хоолох<br>хүний тоо | Салат             |          | Хоол                 |          | Нийт үнэ  |
|---|----------|---------------------|-------------------|----------|----------------------|----------|-----------|
|   |          |                     | Нэг<br>бүрийн үнэ | Бүгд үнэ | Нэг<br>бүрийн<br>үнэ | Бүгд үнэ | Бүгд үнэ  |
| 1 | 10/16    | 50                  | 4000              | 200000   | 6000                 | 300000   | 500000    |
| 2 | 10/17    | 50                  | 4000              | 200000   | 6000                 | 300000   | 500000    |
| 3 | 10/18    | 40                  | 4000              | 160000   | 6000                 | 240000   | 400000    |
| 4 | 10/19    | 40                  | 4000              | 160000   | 6000                 | 240000   | 400000    |
|   |          |                     |                   |          |                      |          | 1.800.000 |

Хоёр. Томилолт, урамшууллын зардал

| № | Газрын нэр        | Хүний<br>тоо | Хоног | 1 хоногийн<br>томилолт | Мөнгөн дүн |
|---|-------------------|--------------|-------|------------------------|------------|
| 1 | Сумдаар           | 9            | 6     | 26500                  | 1.431.000  |
| 2 | Улаанбаатар хотод | 3            | 3     | 69000                  | 621.000    |
| 3 | Урамшуулал        | 12           | 2     | 20000                  | 480.000    |
|   | Дүн               |              |       |                        | 2.532.000  |

Гурав. Бичиг хэргийн зардал

| № | Зардлын нэр    | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Тоо | Мөнгөн дүн     |
|---|----------------|-------------|----------------|-----|----------------|
| 1 | Анонс          | М.кв        | 8000           | 18  | 144000         |
| 2 | Цаас           | боодол      | 9000           | 1   | 9000           |
| 3 | Принтерийн хор | ш           | 10000          | 1   | 10000          |
|   | Дүн            |             |                |     | <b>163.000</b> |

Дөрөв. Шатахууны зардал /Аи93-1550, ДТ-2100 төгрөг/

| №  | Сумын нэр             | Машины марк | Тоо | Явах км | Зарцуулах шатахуун | Нийт үнэ         |
|----|-----------------------|-------------|-----|---------|--------------------|------------------|
| 1  | Цэрэг татлагын товчоо | Пургон      | 1   | 770     | 138                | 213900           |
|    |                       | Бенз 250    | 1   | 850     | 153                | 321300           |
| 2  | Баянхутаг             | Пургон      | 1   | 50      | 9                  | 13950            |
| 3  | Галшар                | Пургон      | 1   | 290     | 52                 | 80600            |
| 4  | Бор-Өндөр             | Пургон      | 1   | 740     | 134                | 207700           |
| 5  | Дархан                | Пургон      | 1   | 290     | 52                 | 80600            |
| 6  | Баянмөнх              | Пургон      | 1   | 200     | 36                 | 55800            |
| 7  | Дэлгэрхаан            | Пургон      | 1   | 290     | 52                 | 80600            |
| 8  | ХБулаан               | Пургон      | 1   | 360     | 64                 | 99200            |
| 9  | Цэнхэрмандал          | Пургон      | 1   | 290     | 52                 | 80600            |
| 10 | Жаргалтхаан           | Пургон      | 1   | 200     | 36                 | 55800            |
| 11 | Мөрөн                 | Пургон      | 1   | 60      | 10                 | 15500            |
| 12 | Өлзийт                | Пургон      | 1   | 100     | 18                 | 27900            |
| 13 | Өмнөдэлгэр            | Пургон      | 1   | 200     | 36                 | 55800            |
| 14 | Гурванбаян            | Пургон      | 1   | 260     | 47                 | 72850            |
| 15 | Батширээт             | Пургон      | 1   | 380     | 68                 | 105400           |
| 16 | Биндэр                | Пургон      | 1   | 360     | 65                 | 100750           |
| 17 | Баян-Адарга           | Пургон      | 1   | 320     | 57                 | 88350            |
| 18 | Дадал                 | Пургон      | 1   | 540     | 98                 | 151900           |
| 19 | Норовлин              | Пургон      | 1   | 400     | 72                 | 111600           |
| 20 | Батноров              | Пургон      | 1   | 200     | 36                 | 55800            |
| 21 | Баян-Овоо             | Пургон      | 1   | 270     | 48                 | 74400            |
| 22 | Бэрх                  | Пургон      | 1   | 140     | 25                 | 38750            |
| 23 | Хэрлэн                | Пургон      | 1   | 100     | 18                 | 27900            |
|    |                       |             |     |         |                    | <b>2.216.950</b> |